

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ (Сонгох даалгавар)

Санамж:

1. Зохиолын хэсгийг анхааралтай уншиж ойлгоорой.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Сонгож авсан үг, өгүүлбэрийг зохиолын хэсгийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. /Даалгавар бүр 2 оноотой/

Нутаг сэлгэх хунгийн энэлэн буюу Дарьгангын дууль

Сэтгэлийн бүрэнхийг гэрэлтүүлэх мэт нэгэн бүл хун Ганга нуурын чигтэй эрслэн нисэж явна. Хунгийн чуулган бол орчлонгийн нэгэн гайхамшиг юм. Намрын адаг сарын Ганга нуур битүү цагаан цэцгээр бүрхэгдэх мэт.

Оройтсон хунд буудал олдохгүй. Гэхдээ эв зүйгээ олоод л багтчихна. Хэдэн өдөр чуулалдаж, хэдэн шөнө ганганалдана. Өндөр уул, өргөн мөрөн, тэнгис далайг үл ажран гэтэлж, аянга цахилгаан, аадрын мөндрийг ч болов хүчит цувааныхаа ган гинжээр холбон сэтлэх эгнээ зайгаа хуваарилан дэглэдэг буй за. Нутаг сэлгэх гэж буй хунгийн дууг удаан сонсох аргагүй. Сэтгэл үймэрч, элэг зүрх өмөлчих гээд. Буцах цувааг нь бүр ч хардаггүй юм. Нас богиносдог гэлцэнэ. Нуур уснаасаа хагацан салахын гуниг зовлонг эдэлж буй энэ мянга мянган амьтдын сэтгэлийн шаналанг хүний өчүүхэн зүрх яахин даах билээ?

Хунгийн сүрэг аян замдаа шөнө гарна. Нэг л өглөө Ганга нуур эль хуль. Уйлж уйлж цэлхэрсэн зовхи мэт эрэг хөвөө нь нойт даан, жихүүцэлтэй бөгөөд гуниглангуй сааралтана. Нуур усанд энэлж гуньсан, эргэцэж халирсан олон амьтдын хоргодохын гуниглант эрчим шингэж үлддэг байх.

Намрын сэрүү оруут хунгийн чуулган үзэхээр ирсэн “зугаалагчид” хурдан хүлгээрээ Дарьгангын элсэрхэг зөөлөн хөрсийг хэгз татан онгилсоор, Ганга нуурын усыг цалгитал тоормосолно. Тэд бургас бараадан гоё эрээн майхан шааж, хөгжим чарлуулан, сархдын үнэрийг сэн татуулан жаргалаа эдэлцгээнэ. Яг энэ үед хун шувууд зовлон эдэлж эхэлнэ...

Байгаль дэлхийн гайхамшгийг үзэж, сэтгэлийнхээ үр жимсийг ургуулах нь юутай сайхан. Ертөнцийн сайханд тэмүүлэх бидний сэтгэл зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал бүү байгаасай.

(Г.Мэнд-Ооёо)

1. Ганга нууранд шувууд яах гэж чуулалдав?
 - A. Нуур усандаа орох гэж
 - B. Хүмүүст гайхамшгийг мэдрүүлэх гэж
 - C. Хаврын улирал учраас
 - D. Нутаг сэлгэх гэж
 - E. Буудалдаа эв зүйгээ олох гэж
2. Яагаад нутаг сэлгэх хунгийн тухай “Нуур уснаасаа хагацан салахын гуниг зовлонг эдэлж буй” гэж бичсэн бэ?
 - A. Хун шувууд нутаг усандаа дасан хоргоддог учраас
 - B. Өндөр уул, өргөн мөрөн, тэнгис далайг гэтлэх нь хэцүү байдаг учраас
 - C. Байгалийн гайхамшгийг мэддэг учраас
 - D. Намрын сэрүү унаж, уйтгартай болдог учраас
 - E. Өвөлжиж чаддаггүй учраас
3. Эхийн өрнөл хэсгийн утгад **хамааралгүй** үгийг сонгоорой.

A. Чуулалдан ганганалдана...	B. Хуваарилан дэглэдэг...	C. Эрслэн нисэж...D.
Энэлж гуньсан...	E. Эдэлж эхэлнэ...	
4. Дүрслэх хэрэглүүр **илрээгүй** хэсгийг сонгоно уу.
 - A. Уйлж уйлж цэлхэрсэн зовхи мэт эрэг хөвөө нь нойт даан...
 - B. Сэтгэлийнхээ үр жимсийг ургуулах нь юутай сайхан ...
 - C. Намрын адаг сарын Ганга нуур битүү цагаан цэцгээр бүрхэгдэх мэт.
 - D. Эргэцэж халирсан олон амьтад...
 - E. Сэтгэлийн бүрэнхийг гэрэлтүүлэх мэт нэгэн бүл хун...

5. Эхийн сэдвийг тодорхойлоорой.
- A. Хүн хүнээ хайрлах тухай
 - B. Үзэсгэлэнт сайхан байгалийн тухай
 - C. Налгар сайхан намрын тухай
 - D. Эх орноороо бахархаж явах тухай
 - E. Байгалиа хайрлах хайрын тухай
6. “Нуур амар бол нугас амар
Далай амар бол загас амар” гэсэн гол санааг илэрхийлсэн хэвшмэл хэлцийн утгыг илэрхийлэх тулгуур өгүүлбэрийг олоорой.
- A. Хунгийн чуулган бол орчлонгийн нэгэн гайхамшиг юм.
 - B. Нутаг сэлгэх гэж буй хунгийн дууг удаан сонсох аргагүй.
 - C. Сархдын үнэрийг сэн татуулан жаргалаа эдэлцгээнэ. Яг энэ үед хун шувууд зовлон эдэлж эхэлнэ...
 - D. Нуур усанд энэлж гуньсан, эргэцэж халирсан олон амьтдын хоргодохын гунилант эрчим шингэж үлддэг байх.
 - E. Буцах цувааг нь бүр ч хардаггүй юм.
7. “Ертөнцийн сайханд тэмүүлэх бидний сэтгэл зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал бүү байгаасай” гэж бичсэнээр зохиолч юуг хэлэхийг хүссэн бэ?
- A. Сайн сайхан зүйлд тэмүүлэх хэрэгтэй гэсэн санааг хэлэхийг хүссэн.
 - B. Шуналгүй байх нь зөв юм гэж хэлэхийг хүссэн.
 - C. Байгалиа сүйтгэхгүй, унаган төрхийг нь хэвээр хадгалж түүнээс сайн сайхныг авахын чухлыг хэлэхийг хүссэн.
 - D. Байгаль дэлхийн гайхамшигийг үзэх нь сайхан байдаг гэсэн санааг хэлэхийг хүссэн.
 - E. Хүн зөвхөн өөртөө л сайн сайхныг авдаг юм гэсэн санааг хэлэхийг хүссэн.
8. “Нуур уснаасаа хагацан салахын гуниг зовлонг эдэлж буй энэ мянга мянган амьтдын сэтгэлийн шаналанг хүний өчүүхэн зүрх яахин даах билээ?” гэсэн өгүүлбэрт сэтгэлийн ямар өнгө аяс илэрсэн бэ?
- A. Бахархсан өнгө аяс
 - B. Өрөвдсөн өнгө аяс
 - C. Биширсэн өнгө аяс
 - D. Харууссан өнгө аяс
 - E. Гэмшсэн өнгө аяс
9. Эхийн хэв маягийг зөв тодорхойлсныг олоорой.
- A. Тайлбарласан эх
 - B. Тоочсон эх
 - C. Хүүрнэсэн эх
 - D. Эргэцүүлсэн эх
 - E. Тоочиж, тайлбарласан эх
10. “Зугаалагчид хунгийн чуулган үзэхээр хурдан хүлгээрээ ирнэ” гэсэн өгүүлбэрээс хоёр бүрэлдэхүүнт цөм бүтцийг олоорой.
- A. Зугаалагчид ирэх
 - B. Хурдан хүлгээрээ ирэх
 - C. Үзэхээр ирэх
 - D. Зугаалагчид хунгийн чуулган үзэх
 - E. Хунгийн чуулган үзэх
11. Эхийн дүрийн үйлээс зүйлчилсэн утгаараа ялгаатай өгүүлбэрийг олоорой.
- A. Нутаг сэлгэх
 - B. Үзэхээр ирэх
 - C. Үл ажран
 - D. Энэлж гуних
 - E. Эв зүйгээ олох

12. “Нуурын эрэг хөвөө нь нойт даан, жихүүцэлтэй **бөгөөд** гуниглангуй сааралтана” гэсэн өгүүлбэрийн онцолсон холбоосыг тохирох үгээр солин найруулаарай.
А.болон В. атал С. гадна D. тусам E. болоод
13. “Ертөнцийн сайханд тэмүүлэх бидний сэтгэл зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал бүү байгаасай” гэсэн өгүүлбэрийг салаалан хувиргасныг олоорой.
А. Бидний сэтгэл авахын шунал бүү байгаасай.
В. Ертөнцийн сайханд тэмүүлэх бидний сэтгэл зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал бүү байгаасай.
С. Байгаль дэлхийн гайхамшгийг үзэж, сайханд тэмүүлэх бидний сэтгэл зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал бүү байгаасай.
D. Зөвхөн өөртөө л сайн сайхныг авахын шунал ертөнцийн сайханд тэмүүлэх бидний сэтгэл бүү байгаасай.
E. Байгалийн сайханд тэмүүлэх хүмүүний сэтгэл зөвхөн амиа хоохойлох шунал бүү байгаасай.
14. Найруулгын алдаатай өгүүлбэрийг олоорой.
А. Чүлтэмийнх Туулын гармыг хорин жил сахисан айл.
В. Газрын мэлмий болсон булаг миний нутагт байдаг даа.
С. Уудаг ундаа багасга, унтдаг нойроо богиносго.
D. Хүн гэдэг амьтан гурван нүдтэй байсан гэж эртний үлгэр, домогт гардаг.
E. Их хааны төрсөн өдрийн ойгоор Бурхан Халдун уулнаа гэрэлт хөшөө сүндэрлүүлэв.
15. “Аянга цахилгаан, аадрын мөндрийг ч болов хүчит цувааныхаа ган гинжээр холбон сэтэлнэ” гэсэн өгүүлбэрийн шууд бус тусагдахуун гишүүнийг олоорой.
А. мөндрийг В. хүчит С. холбон
D. аянга цахилгаан E. ган гинжээр
16. “Сэтгэлийн бүрэнхийг **гэрэлтүүлэх** нэгэн бүл хун Ганга нуурын чигтэй эрслэн нисэж явна” гэсэн өгүүлбэрийн онцолсон өгүүлэхүүнийг яаж хувиргавал зорилгын байц гишүүн өгүүлбэртэй УНӨ болох вэ?
А. гэрэлтүүлээд В. гэрэлтүүлэхээр С. гэрэлтүүлдэг
D. гэрэлтүүлбэл E. гэрэлтүүлэхэд
17. “Нутаг сэлгэх гэж буй хунгийн дууг удаан сонсох аргагүй” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой.
А. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр
В. Угсарсан нийлмэл өгүүлбэр
С. Энгийн нийлмэл өгүүлбэр
D. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр
E. Холимог нийлмэл өгүүлбэр
18. Дараах холбоо үгийн бүтцийг ажиглаад, цэгийн оронд тохирох үгийг олоорой.
Далай тэнгис, бүрэнхийг гэрэлтүүлэх, сайн сайхан, бидний сэтгэл
А. хунгийн сүрэг В. аянга цахилгаан С. сэтгэл үймрэх
D. бургас бараадах E. өөртөө л авах
19. “Намрын сар” гэсэн холбоо үгийн харьяалахын тийн ялгалын нөхцөлийн утга нь аль вэ?
А. Уулюмхэний, юуныэзэмшилдбуйутга В. Орших байр, орон зай заасан утга
С. Бүхлийн хэсгийг заасан утга D. Цаг хугацаа заасан утга
E. Шинж чанар заасан утга
20. Дараах холбоо үгийг ажиглаад, шууд утгаараа байгаа үгийг олоорой.
А. үзэж тарах В. хүч үзэх С. гайхамшгийг үзэх
D. алаг үзэх E. таван жилийн нүүр үзэх

21. Ойролцоо утгатай хэсгийг олоорой.
 A. өмнө хойно В. буцах ирэх С. унах гүйх
 D. адаг сүүл Е. буцаах авах
22. Ерийн,үүсмэл,ганц тоот,харьяалахын тийн ялгал, эзэнд /ерөнхийлөн/ хамаатуулах нөхцөлтэй жинхэнэ нэрийг олоорой.
 A. хунгийн В. хүлгээрээ С. үнэрийг
 D. сэтгэлийнхээ Е. жаргалаа
23. Үгийн бүтцээр зөв задалсныг олоорой.
 A. саар+л+т+на В. амь+т+д+ын С. цэлх+р+0+сэн
 D. ган+гана+лд+0+на Е. эд+л+цгээ+нэ
24. “Дэвтэрээ хавтаслалаа. Тарваганууд намар оройшхын үес өвөлжөх ичээгээ додомдон ноохойгоо зөөж бэлддэг.Номын сангын үүдэнд уулзая” гэсэн өгүүлбэрүүдэд зөв бичгийн дүрмийн алдаатай үг хэд байна вэ?
 A. 5 В. 6 С.7 D. 4 Е. 3
25. Дараах үгээс төрөл биш утгат үгийг олоорой.
 A. бүргэр В. бүрэн С. бүрий
 D. бүрэлз Е. бүрэнхий
26. Үгсийн аймгаар зөв бүлэглэсэн нь аль вэ?
 A. хэдэн, удаан, мэт, хэгз
 B. бидний, өөртөө, тэд, гоё
 C. энэ, олон, яахин, мянга
 D. хүчит, эрээн, өчүүхэн
 E. шөнө, өдөр, нэгэн, зөвхөн
27. Гурван үет бүлэг үгс нь аль вэ?
 A. сэтгэлийн, орчлонгийн, бүрхэгдэх, чуулалдаж, гайхамшгийг
 B. оройтсон, олдохгүй, багтчихна, ганганалдана
 C. хуваарилан, дэглэдэг, амьтдын, бараадан, сархдын
 D. жихүүцэлтэй, цалгитал, жаргалаа, эдэлцгээнэ, шингэж
 E. хардаггүй, үзэхээр, зугаалагчид, чарлуулан, сайхныг
28. Утгатөгсөгүүлбэрбүтээхэдцэгийнорондальбүтээврүүддарааллаараатохирохвэ?
 “Нар...илч буур...д навч шарла.... ногоо гандлаа”
 A.-ын,-сан,-саар В.-аас,-х,-тал С.-ны,-х,-н
 D.-аар,-хуйц,-ж Е.-тай,-х,-магц
29. Үйлээс нэр үг үүсгэх “-лт” дагаврыг найруулгын **хамгийн оновчтой** хэрэглэсэн жишээг олоорой.
 A. Цохиход хөхрөлт үүссэн. В. Ажилд үнэлэлт өгсөн.
 C. Гэр бүлийн салалт ихэссэн. D. Барааны таталт хийгдлээ.
 E. Үнийн хөөрөгдөлт болов.
30. Олон тооны дагаврыг зөв хэрэглэснийг олоорой.
 A. зарим хүмүүс В. голын чулуунууд С. нутгийнхны зан
 D. олон жилүүд Е. бид нар
31. Найруулгын дээд, дунд, доод зэргээр **илрээгүй**бүлэг үгийг олоорой.
 A. аргамаг, морь, адасга В. сансар, хорвоо, ертөнц
 C. зооглох, идэх, гудрах D. мэлмий, нүд, циймэр
 E. өргөө, гэр, овоохой

32. Ажлын төлөвлөгөөний найруулгад **хамааралгүй** үгийг сонгоорой.

- A. Хийх ажлын жагсаалт
- B. ...р ангид сурдаг нь үнэн болно.
- C. Биелэлт
- D. Хугацаа
- E. Хариуцах эзэн

33. “Ус шүүрэх” гэсэн холбоо үгийн зөв бичсэнийг олоорой.

- | | | | | |
|-------|--------|-------|------|-------|
| A | B | C | D | E |
| ZoJK* | ZoJKra | sIKra | sIK* | Zoio* |

34. Холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- | | | | | |
|--------|--------|----------|-----------|---------|
| A | B | C | D | E |
| HeSoJo | Dərobt | fmsokKcI | Joimodəet | MoigKəT |

35. Цэгийн оронд тохирох дагаврыг нөхөж, зүйр цэцэн үг бүтээгээрэй.

- | | | | | | |
|--|------|-----|-----|-----|------|
| KJK* T Homoo0
fəmləo0 , , ,
feilə d0 Homoo0
FBgrISeia , , , | A | B | C | D | E |
| | -deə | -dI | -də | -d0 | -əəə |

36. Монгол бичгээр бичсэн эхийг зөв хөрвүүлснийг олоорой.

- | | | | | | |
|---|--|---|---|---|--|
| YeBgerel.
foikhSeia
fəbt Del Gerōja
Geejo) T DoiKreəit | A | B | C | D | E |
| | Ганцхан төгрөгтэй Гарзгүй сайн явагтун | Хангай төөрөг аавтай Харцгүй сайн яваарай | Ганзага дүүрэн автай Гарзгүй сайн яваарай | Ганцхан дүгрэг эвийг Гарзгүй сайн аваарай | Ганзага дүүрэн аавтай Гарзгүй сайн явагтун |

37. “Баруун талаар нь тойроод харахад
 Балар харанхуй модтой
 Баттай зэндмэнэ эрдэнэ
 Баялаг болгон түгсэн
 Баахан олондоо алдартай
 Баян буурал Алтай минь” гэсэн нь аман зохиолын ямар төрөл вэ?
 А. Бэлгэ дэмбэрлийн үг В. Цэцэн үг С. Ерөөл
 D. Магтаал Е. Хэл зүгшрүүлэх үг
38. Д.Равжаагийн “Ичиг, ичиг” шүлгийн орхигдсон хэсгийг нөхөөрэй.
 “Аяа бас, номыгнийлүүлсэнгүй мэргэд ичиг”
 А. өөртэйгөө В. багштайгаа С. уншлагатайгаа
 D. дүрэмтэйгээ Е. сэтгэлтэйгээ
39. Цав цагаан үүл
 Хаш цагаан үүл
 Цааш нааш давхцаж
 Сүлжиж ороон тогтоод
 Цаадах хөх огторгуйд
 Цасан угалз болж
Цагаан луу хээтэй
Хөх торгоны адил. (Ц.Дамдинсүрэн)
 Шүлгийн тодруулсан мөрд ямар дүрслэх хэрэглүүр илэрсэн бэ?
 А. Егөөдөл В. Төлөөлөл С. Хүншүүлэл D. Юмшуулал Е. Зүйрлэл
40. Ишданзанванжилын “Гүнгийн зуугийн гэгээний Алтан сургаал”-аас эцэг эхийн ачлалыг биширч, элбэрэл журмыг эрхэмлэн явахын учрыг сануулсан утгатай хэсгийг олж сонгоно уу.
 А. Хэрэг үгүй шунал, нэр алдар барна
 Хээ үгүй нүүр сэтгэл, хүмүүний чанар дуусгана.
 В. Хүүхнээ сургалгүй золбин эм болговол
 Хүмүн бүрийг бузарлаж, аймаг улс гутна.
 С. Ховор номлол хэлэх нь их номчийн үгтэй
 Хонины мах идэх нь чоно нохойн шуналтай
 D. Хочлолдон эвдрэхийн шалтгаан дор хүрвэл
 Гутамшигт зовлонг бүгдээр хүртэнэ.
 E. Усгалаар бүүвэйлж урнаар дуудан
 Улбай (бузгай сайн) хүмүүн болгосон.

ХОЁРДУГААР ХЭСЭГ (Харгалзуулах даалгавар)**Санамж:**

- Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Хэлцийг ойролцоо утгаар нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-----------------------------------|------------------------------------|
| a. Чонын эзгүйд чандага ноён | 1. Гаднаа гяланцаг дотроо паланцаг |
| b. Хэрээ лууны маханд дурлах | 2. Могой алахад модны нэмэргүй |
| c. Өнгө нь наанаа өргөс нь цаанаа | 3. Ниргэсэн хойно нь хашхирах |
| d. Айхын бараа идэхийн нэмэр | 4. Нохойгүйд гахай хуцна |
| e. Үнээ үхэхдээ сүү орох | 5. Хөл нь хөнжилд санаа нь саранд |

2.2 Зохиолын өгүүлэгдэхүүний бүрдэл хэсгүүдийн тодорхойлолтыг зөв хариутай нь харгалзуулаарай.

- | | |
|-------------|---|
| a. Төгсгөл | 1. Зохиолын эхлэл хэсгийг залган хөгжүүлж, улмаар зөрчил үүсгэн, үйл явдлын цаашдын өрнөх шалтгаан болж буй хэсэг |
| b. Эхлэл | 2. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл алгуур хөгжсөөр цаашид үргэлжлэх аргагүй болтлоо хурцдаж, дээд цэгтээ хүрсэн хэсэг |
| c. Зангилаа | 3. Өгүүлэгдэхүүний өрнөх дэвсгэр суурь бөгөөд цаашид зохиолын зөрчил, тэмцэл гарах ахуй амьдрал, нийгмийн нөхцөл, гол баатруудын тухай танилцуулдаг хэсэг |
| d. Туйл | 4. Зохиолчийн өөрийн үнэлэмж, хандлага, дүгнэлт бүхий хэсэг |
| e. Өрнөл | 5. Зангилаа бий болсноос хойш тэрхүү эгзэгтэй зангилааны учир зүйг олохын тулд чөлөөтэй өрнөж буй хэсэг |

2.3 Үгийн утгыг тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|------------------|--|
| a. аадар бороо | 1. хувингаар цутгасан мэт орох бороо |
| b. цутгал бороо | 2. их далай тэнгисийн усархаг бороо |
| c. азарган бороо | 3. ширүүн усархаг бороо |
| d. юүлүүр бороо | 4. түр зуурын ширүүн бороо |
| e. асгал бороо | 5. гэнэт ихээр орсон, түр зуурын асгасан мэт бороо |

2.4 Зөвийг нь олж харгалзуулаарай.

		1	2	3	4	5
a	Цагт нэрийн “-сан ⁴ ” дагаврыгбуруу бичсэн үг	одсоныг	нээснээр	хожсоны	сууснаас	өгсөнийг
b	“ыг”нөхцөлийг бичих үг	урц	зураач	боломж	зураг	толь
c	Гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад балархай эгшгийг өмнө нь бичих үг	хов+л	зар+л	баг+л	хил+л	нүд+л
d	Балархай эгшиг нь гээгдэхгүй үг	хожил+ыг	сорил+ын	хуучин+аас	ажил+аар	орчин+ыг
e	Зөөлний тэмдэг “и” болох үг	барь+даг	шаагь+ж	холь+чих	тарь+сан	захь+жээ